



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 01 өдөр

Дугаар A/406

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны A/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүтэц орон тооны өөрчлөлт хийгдсэнтэй холбогдуулан 2019 оны A/319 дүгээр тушаалын хавсралт ёсоор баталсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Ажлын хэсгийн ахлагч – Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл менежментийн хэлтсийн дарга “М.Энхболд” гэснийг “С.Ариунжаргал”, Нарийн бичгийн дарга – Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн “Б.Наранцацрал” гэснийг “Б.Эрдэнэчулуун” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” A/219 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны үр дүнд нийлүүлэгдэж буй оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийг нийлүүлэх багц-1, багц-6, багц-8-ыг тус тус тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001213